

“Жисаса” ХХК-д валют солих цэгийн үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Валют солих цэгийн үйл ажиллагааны зохицуулалтын түр журам”-ын 5.4 дэх хэсэг болон “Жисаса” ХХК-ийн үүсгэн байгуулагчийн 2008 оны 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жисаса” ХХК-д валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Жисаса ” ХХК /Ж.Галдан/ -д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ